

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Хулд сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2024/136/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.open.audit.mn

Дундговь аймаг

2024 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал
Утас: 70592225
Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Их наяд аудит ХХК
Захирал: Х.Ариунзул
Утас: 99077062
Цахим хаяг: ikhayadaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208. Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2024-02-26 № 72.

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Хулд сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Хулд сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант оны дундуур халаалтын тарифыг нэмэгдүүлж мөрдүүлсэнтэй холбоотой үүссэн өр төлбөр болон Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2023 оны 07 сарын 01-ээр төрийн албаны үндсэн цалинг нэмсэн, бараа материалын үнэ, тарифын өсөлттэй холбоотой нийт зардал өмнөх оноос 1.4 дахин өссөн байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж, татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлогын бичиг баримт болон хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг 93.5 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	45,120,628.52	71,443,635.53
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,366,713.02	29,509,322.03
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	6,366,713.02	29,509,322.03
3121	Төгрөг	6,366,713.02	29,509,322.03
31211	Төрийн сангийн харилцах	6,214,233.99	29,356,843.00
31218	Ахмадын сангийн харилцах	152,479.03	152,479.03
35	БАРАА МАТЕРИАЛ	38,753,915.50	41,934,313.50
351	Түүхий эд материал	9,012,238.00	10,662,238.00
35110	Тусгай зориулалттай материал	9,012,238.00	10,662,238.00
354	Хангамжийн материал	29,741,677.50	31,272,075.50
35410	Бичиг хэргийн материал	80,000.00	385,000.00
35420	Аж ахуйн материал	25,878,907.50	26,088,307.50
35460	Хүнсний материал	3,782,770.00	4,798,768.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	375,788,158.65	385,026,226.61
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	375,788,158.65	385,026,226.61
392	Биет хөрөнгө	347,188,158.65	356,426,226.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	354,467,095.78	354,467,095.78
39202	Хуримтлагдсан элэгдэл	(56,678,772.64)	(70,307,840.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	43,616,315.48	76,074,920.48
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,130,005.06)	(26,310,898.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,811,472.16	34,811,472.16
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,441,512.80)	(18,442,611.40)
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,329,868.00	13,329,868.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,786,302.27)	(7,195,778.95)
393	Биет бус хөрөнгө	28,600,000.00	28,600,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	28,600,000.00	28,600,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	420,908,787.17	456,469,862.14
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,693,340.00	8,916,650.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,693,340.00	8,916,650.00
413	Өглөг	5,693,340.00	8,916,650.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	5,395,340.00	8,618,650.00
413201	Бичиг хэргийн өглөг	0.00	220,000.00
413205	Тээвэр, шатахууны өглөг	4,262,790.00	4,262,790.00
413208	Хоолны өглөг	0.00	2,829,510.00
36141	Байгууллагад төлөх өглөг	1,332,550.00	1,306,350.00
4136	Бусад өглөг	298,000.00	298,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	298,000.00	298,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	415,215,447.17	447,553,212.14
51	Засгийн газрын хувь оролцоо	415,215,447.17	447,553,212.14
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	128,219,876.43	128,219,876.43
51101	Өмч: - төрийн	128,219,876.43	128,219,876.43
512	Хуримтлагдсан үр дүн	37,299,914.13	69,637,679.10
51210	Өмнөх үеийн үр дүн	(373,986,333.04)	37,299,914.13
51220	Тайлант үеийн үр дүн	411,286,247.17	32,337,764.97
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	249,695,656.61	249,695,656.61
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	420,908,787.17	456,469,862.14

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	372,742,779.03	480,075,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28,516,279.03	36,003,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	28,516,279.03	33,640,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	255,979.03	33,640,000.00
120017	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	27,563,450.00	36,003,800.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	696,850.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	344,226,500.00	444,071,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	291,380,500.00	405,662,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	291,380,500.00	405,662,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	52,846,000.00	38,408,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,846,000.00	38,408,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	367,246,709.12	447,719,601.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	367,246,709.12	447,719,601.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	367,002,062.77	447,690,764.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	233,654,317.00	290,710,418.00
210101	Үндсэн цалин	162,613,099.00	209,538,501.00
210102	Нэмэгдэл	54,592,334.00	70,581,250.00
210104	Урамшуулал	16,448,884.00	10,590,667.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,556,008.00	35,875,529.99
210201	Тэтгэврийн даатгал	20,068,632.29	24,804,848.15
210202	Тэтгэмжийн даатгал	2,416,565.12	2,812,648.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,885,556.32	2,325,674.47
210204	Ажилгүйдлийн даатгал	471,414.30	531,680.29
210205	Эрүүл мэндийн даатгал	4,713,839.97	5,400,678.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,475,259.65	35,203,663.41
210301	Гэрэл, цахилгаан	1,955,731.65	2,835,163.41
210302	Түлш, халаалт	23,149,528.00	30,973,500.00
210303	Цэвэр, бохир ус	370,000.00	1,395,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,087,515.00	8,478,200.00
210401	Бичиг хэрэг	698,500.00	2,431,100.00
210402	Тээвэр, шатахуун	5,407,465.00	1,853,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	200,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,661,550.00	4,194,000.00
2105	Нормативт зардал	28,435,370.01	42,515,250.00
210502	Хоол, хүнс	28,435,370.01	42,515,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,065,600.00	3,056,700.00
210604	Урсгал засвар	7,065,600.00	3,056,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	583,000.00	860,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	583,000.00	686,900.00
210813	Бусад зардал-ТӨҮГ		173,800.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,144,993.11	30,990,303.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,955,600.00	3,373,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,309,150.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,880,243.11	27,616,703.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	244,646.35	28,836.59
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	244,646.35	28,836.59

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	244,646.35	28,836.59
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	5,496,069.91	32,355,598.67
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	17,833.70
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	17,833.70
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-	(17,833.70)
5	НИЙТ ҮР ДҮН	5,496,069.91	32,337,764.97

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	344,482,479.03	444,071,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	255,979.03	-
120	Нийтлэг татварын бус орлого	255,979.03	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	255,979.03	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	103,500.00	-
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	152,479.03	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	344,226,500.00	444,071,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	291,380,500.00	405,662,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	291,380,500.00	405,662,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	52,846,000.00	38,408,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,846,000.00	38,408,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	337,016,766.01	420,059,985.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	337,016,766.01	420,059,985.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	336,772,119.66	420,031,149.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	233,654,317.00	290,710,418.00
210101	Үндсэн цалин	162,613,099.00	214,156,075.00
210102	Нэмэгдэл	54,592,334.00	64,646,915.00
210104	Урамшуулал	16,448,884.00	11,907,428.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,556,008.00	35,875,529.99
210201	Тэтгэврийн даатгал	20,068,632.29	24,710,384.15
210202	Тэтгэмжийн даатгал	2,416,565.12	2,907,104.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,885,556.32	2,325,683.47
210204	Ажилгүйдлийн даатгал	471,414.30	531,680.29
210205	Эрүүл мэндийн даатгал	4,713,839.97	5,400,677.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,117,759.65	35,203,663.41
210301	Гэрэл, цахилгаан	1,955,731.65	2,835,163.41
210302	Түлш, халаалт	22,792,028.00	30,973,500.00
210303	Цэвэр, бохир ус	370,000.00	1,395,000.00
2105	Нормативт зардал	29,926,510.01	40,701,738.00
210502	Хоол, хүнс	29,926,510.01	40,701,738.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,814,000.00	3,176,200.00
210604	Урсгал засвар	6,814,000.00	3,176,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	583,000.00	686,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	583,000.00	686,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,120,525.00	13,676,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,427,875.00	11,580,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,692,650.00	2,095,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	244,646.35	28,836.59
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	244,646.35	28,836.59
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	244,646.35	28,836.59
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	7,465,713.02	24,011,414.01
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,099,000.00	868,805.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,099,000.00	868,805.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,099,000.00	868,805.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,099,000.00	868,805.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,099,000.00)	(868,805.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	6,366,713.02	23,142,609.01
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	6,366,713.02
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,366,713.02	29,509,322.03

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	128,219,876.43	249,695,656.61	31,803,844.22	409,719,377.26
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	128,219,876.43	249,695,656.61	31,803,844.22	409,719,377.26
Тайлант үеийн үр дүн			5,496,069.91	5,496,069.91
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	128,219,876.43	249,695,656.61	37,299,914.13	415,215,447.17
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	128,219,876.43	249,695,656.61	37,299,914.13	415,215,447.17
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	128,219,876.43	249,695,656.61	37,299,914.13	415,215,447.17
Тайлант үеийн үр дүн			32,337,764.97	32,337,764.97
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	128,219,876.43	249,695,656.61	69,637,679.10	447,553,212.14

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	462,289,300.00	420,899,954.40	(41,389,345.60)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	462,289,300.00	420,899,954.40	(41,389,345.60)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	462,289,300.00	420,899,954.40	(41,389,345.60)
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	320,331,300.00	290,710,418.00	(29,620,882.00)
210101	Үндсэн цалин	218,569,100.00	214,156,075.00	(4,413,025.00)
210102	Нэмэгдэл	92,823,000.00	64,646,915.00	(28,176,085.00)
210104	Урамшуулал	8,939,200.00	11,907,428.00	2,968,228.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,041,300.00	35,875,529.99	(4,165,770.01)
210201	Тэтгэврийн даатгал	27,241,300.00	24,710,384.15	(2,530,915.85)
210202	Тэтгэмжийн даатгал	3,200,000.00	2,907,104.18	(292,895.82)
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,559,900.00	2,325,683.47	(234,216.53)
210204	Ажилгүйдлийн даатгал	640,000.00	531,680.29	(108,319.71)
210205	Эрүүл мэндийн даатгал	6,400,100.00	5,400,677.90	(999,422.10)
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,208,700.00	35,203,663.41	(5,036.59)
210301	Гэрэл, цахилгаан	2,835,200.00	2,835,163.41	(36.59)
210302	Түлш, халаалт	30,423,500.00	30,973,500.00	550,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,950,000.00	1,395,000.00	(555,000.00)
2105	Нормативт зардал	47,874,500.00	40,701,738.00	(7,172,762.00)
210502	Хоол, хүнс	47,874,500.00	40,701,738.00	(7,172,762.00)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,200,000.00	3,176,200.00	(23,800.00)
210604	Урсгал засвар	3,200,000.00	3,176,200.00	(23,800.00)

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	699,200.00	686,900.00	(12,300.00)
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	699,200.00	686,900.00	(12,300.00)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,934,300.00	14,545,505.00	(388,795.00)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,836,600.00	12,449,705.00	(386,895.00)
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,097,700.00	2,095,800.00	(1,900.00)
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	456,075,700.00	440,089,800.00	(15,985,900.00)
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	456,075,700.00	440,089,800.00	(15,985,900.00)
122005	Орон нутгийн төсвөөс	456,075,700.00	440,089,800.00	(15,985,900.00)
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	6,366,713.02	6,366,713.02
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	29,509,322.03	29,509,322.03

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,381.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 5,693.3 мянган төгрөгийн 1 зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага, 688.5 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ И баримтыг дутуу бүрдүүлсэн.	1	688.5					1	688.5
Санхүүгийн тайлан дахь 5,693.4 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ аваагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй	1	5,693.3			1	5,693.3		
Дүн	2	6,381.8			1	5,693.3	1	688.5
Нийт дүн	2	6,381.8			1	5,693.3	1	688.5